БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/96/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: С.Нурлан<br>Утас: 94209011 Цахим хаяг:nurlans@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....**Error! Bookmark not defined.**
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4 Материаллаг байдал ....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....14
3.8 Аудитын гол асуудал ....15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт ....16
4.1 Залруулсан алдаа.... 16
4.2 Төлбөрийн акт.... 16
Байхгүй .... 16
4.3 Албан шаардлага .... 16
4.4 Зөвлөмж .... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦАГААННУУР ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.АРЫСТАН ТАНАА

2022.02.21 № 86
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Dugnelt 2.18-TA

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Dugnelt 2.18-TA

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2718096.00** | **2718096.01** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2718096.00 | 2718096.01 |
| **354** | **Хангамжийн материал** | 2718096.00 | 2718096.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 35000.00 | 35000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1026800.00 | 1026800.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1656296.00 | 1656296.01 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **387492994.37** | **343031926.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 387492994.37 | 343031926.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 382246594.37 | 337785526.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 316644704.45 | 311866104.45 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -29504891.00 | -48678536.02 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 92329999.00 | 91089999.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -48187777.50 | -54780833.11 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54985684.00 | 58178684.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42317791.14 | -44881122.78 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19360590.00 | 19360590.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16637173.50 | -18363339.70 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 911067686.82 | 695747679.16 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -875524436.76 | -671783698.33 |
| 39217 | Ном | 30000.00 | 30000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5246400.00 | 5246400.00 |
| 39301 | Програм хангамж | 1681400.00 | 1681400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1681400.00 | -1681400.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5246400.00 | 5246400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **390211090.37** | **345750022.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **12655633.00** | **19046644.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 12655633.00 | 19046644.00 |
| **413** | **Өглөг** | 12655633.00 | 19046644.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 12655633.00 | 19046644.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **377555457.37** | **326703378.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 377555457.37 | 326703378.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 876594219.00 | 876594219.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 876594219.00 | 876594219.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -902524964.06 | -847633464.66 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -902524964.06 | -796781385.97 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -50852078.69 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 403486202.43 | 297742624.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **390211090.37** | **345750022.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **240,920,456.00** | **227,242,211.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **30,783,999.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 30,783,999.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 30,783,999.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 30,783,999.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **210,136,457.00** | **227,242,211.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 11,459,000.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 11,459,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,348,357.00 | 1,336,011.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,348,357.00 | 693,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 643,011.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 206,788,100.00 | 214,447,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 206,788,100.00 | 214,447,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **236,196,946.30** | **266,407,420.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **236,196,946.30** | **266,407,420.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 236,196,946.30 | 244,671,020.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,198,851.00 | 148,529,731.00 |
| 210101 | Үндсэн цалин | 107,503,451.00 | 97,379,788.80 |
| 210102 | Нэмэгдэл | 34,018,000.00 | 26,450,217.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,372,273.00 | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,305,127.00 | 24,699,724.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,857,800.00 | 18,773,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,270,300.00 | 13,011,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,396,900.00 | 1,440,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,117,500.00 | 1,152,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 279,400.00 | 288,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,793,700.00 | 2,881,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,226,600.00 | 8,061,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 702,800.00 | 855,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,150,600.00 | 6,817,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 373,200.00 | 388,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,648,478.00 | 8,273,247.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,173,678.00 | 1,537,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,526,800.00 | 6,170,797.99 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 948,000.00 | 477,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 88,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 147,700.00 | 261,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 147,700.00 | 261,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 993,400.00 | 130,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 993,400.00 | 130,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,113,600.00 | 1,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,113,600.00 | 1,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,180,700.00 | 970,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,300.00 | 150,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 382,800.00 | 176,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 203,900.00 | 149,780.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,600.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 293,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 69,800.00 | 50,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,829,817.30 | 58,170,961.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,310,127.00 | 12,871,363.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 262,122.00 | 373,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,257,568.30 | 44,926,198.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 21,736,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 21,736,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 21,736,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,723,509.70** | **(39,165,209.07)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 11,686,869.62 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 11,686,869.62 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (11,686,869.62) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,723,509.70** | **(50,852,078.69)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 876,594,219.00 | 403,486,202.43 | -907,248,473.76 | 372,831,947.67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **876,594,219.00** | **403,486,202.43** | **-907,248,473.76** | 372,831,947.67 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 4,723,509.70 | 4,723,509.70 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **403,486,202.43** | **-902,524,964.06** | 377,555,457.37 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **403,486,202.43** | **-902,524,964.06** | 377,555,457.37 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 105,743,578.09 | 105,743,578.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **876,594,219.00** | **403,486,202.43** | **-796,781,385.97** | 483,299,035.46 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -105,743,578.09 | | -105,743,578.09 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -50,852,078.69 | -50,852,078.69 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **297,742,624.34** | **-847,633,464.66** | 326,703,378.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **210136457.00** | **215783211.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **210136457.00** | **215783211.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3348357.00 | 1336011.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3348357.00 | 693000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 643011.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 206788100.00 | 214447200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 206788100.00 | 214447200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **210136457.00** | **215090211.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **210136457.00** | **215090211.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **210136457.00** | **193353811.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157387700.00 | 142066400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 107692300.00 | 90140115.80 |
| 210102 | Нэмэгдэл | 33578000.00 | 26807518.40 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16117400.00 | 25118765.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18857800.00 | 18774000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13270300.00 | 13011400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1396900.00 | 1440700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1117500.00 | 1152500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 279400.00 | 288100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2793700.00 | 2881300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11835800.00 | 9565700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 702800.00 | 855700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10744900.00 | 8321900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 388100.00 | 388100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14799900.00 | 6642648.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 989900.00 | 1351000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12842000.00 | 4480648.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 968000.00 | 723000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 88000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 146700.00 | 261400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 146700.00 | 261400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 993400.00 | 300000.00 |
| 210604 | Урсгал засвар | 993400.00 | 300000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1113600.00 | 1500000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1113600.00 | 1500000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1406400.00 | 1042300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 224000.00 | 150400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300100.00 | 176800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108300.00 | 90300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 203900.00 | 168900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95600.00 | 75000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 359100.00 | 293600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 45600.00 | 37300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 69800.00 | 50000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3595157.00 | 13201363.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3318357.00 | 12701363.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 276800.00 | 500000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **21736400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 21736400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 21736400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **693000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **693000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **693000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 693000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 693000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-693000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 214596200.00 | 214447200.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 214596200.00 | 214447200.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 192859800.00 | 192710800.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 142066400.00 | 142066400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 83286300.00 | 90140115.80 |
| 210102 | Нэмэгдэл | 24914900.00 | 26807518.40 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33865200.00 | 25118765.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд** | 18774000.00 | 18774000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **төлөх шимтгэл** | | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13011400.00 | 13011400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1440700.00 | 1440700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1152500.00 | 1152500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 288100.00 | 288100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2881300.00 | 2881300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9565700.00 | 9565700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 855700.00 | 855700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8321900.00 | 8321900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 388100.00 | 388100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6681000.00 | 6532000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1500000.00 | 1351000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4370000.00 | 4370000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 723000.00 | 723000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88000.00 | 88000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 261400.00 | 261400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 261400.00 | 261400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 300000.00 | 300000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300000.00 | 300000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1500000.00 | 1500000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1500000.00 | 1500000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1042300.00 | 1042300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150400.00 | 150400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 176800.00 | 176800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90300.00 | 90300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 168900.00 | 168900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75000.00 | 75000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 293600.00 | 293600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37300.00 | 37300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 50000.00 | 50000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12669000.00 | 12669000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12169000.00 | 12169000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500000.00 | 500000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21736400.00 | 21736400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21736400.00 | 21736400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21736400.00 | 21736400.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 214596200.00 | 214596200.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 214596200.00 | 214596200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 214596200.00 | 214596200.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.00 | 23.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 4.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 12.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.00 | 6.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1336011.00** | **1336011.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1336011.00** | **1336011.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1336011.00 | 1336011.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 110648.00 | 110648.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 110648.00 | 110648.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1225363.00 | 1225363.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1225363.00 | 1225363.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1336011.00 | 1336011.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1336011.00 | 1336011.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 693000.00 | 693000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 643011.00 | 643011.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:
Цагааннуур тосгоны Захирагчийн алба нь Монгол улсын ЗЗНДНТУТухай хуульд заасан чиг үүргийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилладаг ба Төрийн албаны хууль мөн бусад хууль, тогтоомжуудыг дагаж мөрдөх, авлага, ашиг сонирхлын зөрчилд автахгүй үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг мөрдөж, ард иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод хүргэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас тус байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдээгүй байна.

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 236.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44.4 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 2718.1 | 2718.1 | |
| Үндсэн хөрөнгө | 387493.0 | 343031.9 | -44461.1 |
| **Нийт хөрөнгө** | **390211.1** | **345750,0** | **44461.1** |
| Өр төлбөр | 12655.6 | 19046.6 | 6391.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 377555.5 | 326703.4 | -50852.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **390211.1** | **345750.0** | **44461.1** |

Бараа материал дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй ба тайлант онд 23.6 сая төгрөгийн материал худалдан авч, зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 343.0 сая төгрөг болж 44.4 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 0.7 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 11.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 230.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 44.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 50.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 227.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 13.0 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого байна.

Нийт зардал 266.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 30.2 сая төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад бараа үйлчилгээний зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар акталсан хөрөнгийн дахин үнэлгээний бууралттай холбоотой нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны анх батлагдсан төсөв 200.4 сая төгрөг, тодотгосон төсөв 214.6 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 14.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалингийн зардлыг 3.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 11.2 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Цагааннуур тосгоны Захирагчийн алба нь тайлант онд 214.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 214.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн 66.2 хувийг цалин, 8.8 хувийг НДШ-ийн зардал, 4.5 хувийг тогтмол зардал, 3.0 хувийг хангамж бараа материалын зардал, 5.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 10.1 хувийг урсгал шилжүүлэг, үлдсэн хувийг бусад жижиг зардлууд тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалин, НДШ-ийн зардал, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэгт нийтдээ 212.5 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс нийт 18.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.8 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсөвт төвлөрүүлсэн санхүүжилт байхгүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цагааннуур тосгоны Захирагчийн алба нь 2021 онд нийт 210.2 сая төгрөгийн 19 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 16 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2 мэдээллийг мэдээлээгүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь өр үүсгэсэнтэй холбоотой төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар орон тоо хэтрүүлэн жилийн эцэст 12.6 сая төгрөгийн өртэй гарсан, нярав нь тээвэр шатахуун, түлш халаалтын зардлын тайлан гаргаагүй, дутуу орлого авсан, шууд зардлаар бүртгэсэн зөрчилд албан шаардлага, Шилэн дансны 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд өр төлбөр 19.0 сая төгрөг болж нэмэгдсэн, бусад зөрчлүүдийг арилгаж, шилэн данстай холбоотой зөвлөмж хэрэгжсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,5 сая төгрөгийн зөрчил илэрч 20,5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, шилэн данстай холбоотой зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 20,5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/845 дугаар захирамж, Ногооннуур сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Захирагчийн албаны орон тоо 18 хүнээр батлагдсан боловч шинээр 5 орон тоо бий болгож 23 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж, эдгээр орон тооны цалингийн зардалд нийт 29,629.8 мянган төгрөгийг зарцуулсан нь жилийн эцэст цалингийн татварт 10,168.7 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын шимтгэлд 8,647.9 мянган төгрөгийн нийт 19,046.6 мянган төгрөгийн өглөгтэй гарахад нөлөөлсөн байна. Өмнөх аудитаар орон тоо хэтрүүлж өр үүсгэсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна

1. Цагааннуур тосгоны Захирагчийн алба нь 2021 онд гүйцэтгэлээр 214,447.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 18,010.3 мянган төгрөгийн төсвийн 10 хувь буюу 1,801.0 мянган төгрөгөөр хэмнэлт гаргахаар тооцож, төлөвлөж, зарцуулаагүй, тогтоолын 1.6-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 1,511.9 мянган төгрөгийг шинэ жилийн бэлэг худалдан авахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, *41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн* 41.2.3, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар

тогтоолын 1.1-т ”үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.6-т 1.6. “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цагааннуур тосгоны Захирагчийн алба | 2 | 20.5 | | | | | 2 | 20.5 | | |